

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/33

Арвайхээр сум

Улирлын томуугийн эсрэг  
вакцинаар дархлаажуулах тухай

“Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/512 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:


1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2022 оны 10 дугаар сарын 20-30-ны өдрүүдэд “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулсугай.
2. Монгол Улсын Засгийн газрын хөрөнгөөр худалдан авсан Бүгд Найрамдах Солонгос Улсын Грийн кросс үйлдвэрийн улирлын томуугийн вакцинаар эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 1-5 насны хүүхэд болон эрсдэлт бүлгийн хүн ам, эрүүл мэндийн ажилтныг вакцинжуулах ажлыг зохион байгуулахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Дархлаажуулалтын 10 хоногоор заавал хийх товлолын дархлаажуулалтаас хоцорсон 0-15 насны хүүхдийг нөхөн дархлаажуулах, дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.
4. Улирлын томуугийн эсрэг “GCFLU” вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг хавсралтаар баталсугай.
5. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А/512 дугаар тушаалаар батлагдсан вакцины зааврын дагуу эрсдэлт бүлгийн хүн амыг вакцинжуулж, мэдээг батлагдсан маягтын дагуу өдөр бүрийн 17 цагт мэдээлэх, хуваарилсан вакцин, дагалдах хэрэгслийг хүлээн авч, эргэлтийн хөрөнгөд бүртгэн, зарцуулалтад нь хяналт тавьж, санхүүгийн тайланд тусгахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, сум өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын 2022 оны  
10 дугаар сарын 20 өдрийн 133 дугаар  
тушаалын хавсралт



Улирлын томуугийн эсрэг "GCFLU" вакцин, дагалдах хэрэгслийн хуваарь

№	Сумын нэр	Вакцинд хамруулах зорилтот бүлэг				Шаардлагатай вакцин, тариур	
		1-5 хүртэлх насны хүүхэд	Эрүүл мэндийн байгууллагын ажилтан	Жирэмсэн эмэгтэйчүүд	Эрсдэлт бүлгийн хүн ам /65 болон түүнээс дээш насны хүмүүс, архаг хууч өвчтэй иргэд	Олгох хүн тун	Тариур 1 мл
		50%		70%			
1	БаруунБаян-Улаан	180	20	14	86	300	300
2	Бат-Өлзий	450	38	85	237	810	810
3	Баянгол	210	26	41	133	410	410
4	Баян-Өндөр	210	24	31	205	470	470
5	Богд	410	34	70	166	680	680
6	Бүрд	170	20	18	142	350	350
7	Гучин-Ус	120	19	19	42	200	200
8	Зүйл	160	27	24	139	350	350
9	ЗБУ	210	22	26	162	420	420
10	Нарийнтээл	210	34	34	132	410	410
11	Өлзийт	120	20	10	140	290	290
12	Сант	190	19	24	157	390	390
13	Тарагт	190	25	24	151	390	390
14	Төгрөг	150	20	17	103	290	290
15	Уянга	600	54	114	292	1060	1060
16	Хайрхандулаан	210	26	29	155	420	420
17	Хархорин	730	134	130	736	1730	1730
18	Хужирт	390	37	80	363	870	870
19	Нарны дөш	1000	22	220	518	1760	1760
20	Уянсэтгэл	700	20	140	420	1280	1280
21	Түшигдөлгөөн	690	19	130	521	1360	1360
22	ЭМГ, БОЭТ, ЗӨСТ		300	0		300	300
23	Хувийн хэвшил		120			120	120
	<b>Нийт тоо</b>	<b>7300</b>	<b>1080</b>	<b>1280</b>	<b>5000</b>	<b>14660</b>	<b>14660</b>